



**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/167

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/187 дугаар тушаалын 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан аргачлалыг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэхэд баримталж ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Аргачлалыг хэрэгжүүлэх зөвлөмж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газар (Д.Баасансүрэн)-т даалгасугай.

ДАРГА



Л.ДАШДЭМБЭРЭЛ

000565

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын
даргын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн
А/67 дугаар тушаалын хавсралт

**“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙГ БИЕ ДААН АМЬДРАХАД НЬ ДЭМЖЛЭГ
ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАХ ИРГЭНИЙ ТОО, ШААРДАГДАХ
ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ**

Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхэд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлоход энэхүү аргачлалыг ашиглана.

Аргачлал нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1-32.6 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/187 дугаар тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”, “Хувийн туслах үйлчилгээнд тавигдах шалгуур”, “Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд тавигдах шалгуур”-т тус тус үндэслэнэ.

1. Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээ:

1.1 Харилцан суралцах үйлчилгээг үзүүлэх төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/187 дугаар тушаалаар баталсан “Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд тавигдах шалгуур”-ыг баримтлана.

1.2 Сургалтын жишиг хөтөлбөрийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

1.3 Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх иргэн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн байна.

1.4 Харилцан суралцах үйлчилгээ нь дараах төрөлтэй байна.

1.4.1. Эерэг сэтгэлгээг хөгжүүлэх, өөдрөг хандлага ба амьдралыг үзэх үзэл, үнэлэмжээ дээшлүүлэх, харилцаа хандлага, эрүүл амьдарлын хэв маягийг хэвшүүлэхэд өөрийгөө зөв илэрхийлж, бусадтай харилцах чадвар олгох сургалт;

1.4.2. Өдөр тутмын үйлдэл хийхэд шаардлагатай ахуйн болон тэргэнцэр, туслах хэрэгсэл зэргийг ашиглах сургалт;

1.4.3. Өдөр тутмын харилцаанд орох дохионы хэлний анхан шатны сургалт;

1.4.4. Цагаан таяг эзэмшиж сурах болон хөдөлгөөн, орон зайн чиг баримжаа олгох сургалт;

1.4.5. Туслах технологийн сургалт;

1.4.6. Ахуйн сургалт;

1.4.7. Брайль бичгийн сургалт;

2. Эерэг сэтгэлгээг хөгжүүлэх, өөдрөг хандлага ба амьдралыг үзэх үзэл, үнэлэмжээ дээшлүүлэх, харилцаа хандлага, эрүүл амьдарлын хэв маягийг хэвшүүлэхэд өөрийгөө зөв илэрхийлж, бусадтай харилцах чадвар олгох сургалт

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт заасан иргэн хамрагдах бөгөөд нэг багшид ноогдох анги дүүргэлт өөр өөр байх бөгөөд 10-аас 15 хүртэл суралцагч суралцана.

2.2. Суралцагчийн 1 өдөрт хамрагдах сургалтын цагийн дээд хэмжээ 3 цаг, багшийн хувьд 6 цаг хүртэл байна.

2.3. Сургалтын өмнө оролцогчдоос сургалтын өмнөх мэдлэг, чадварыг тогтоосон тест авна. Сургалтын дараа дахин тест болон сэтгэл ханамжийн судалгаа авсан байх шаардлагатай.

2.4. Сургагч багшийн ажлын нэг цагийн хөлсийг 20000 төгрөгөөр тооцно.

2.5. Сургалтын хөтөлбөрийн онцлог, сургалтанд хамрагдаж байгаа зорилтот бүлгийн иргэдийн хэрэгцээ, шаардлагаас хамаарч сургалт үргэлжлэх хугацаа нь ажлын 1-5 өдөр байна.

2.6. Сургалтын үргэлжлэх хугацаанаас үл хамаарч бичиг хэргийн зардлыг 1 удаа олгоно.

Нэг суралцагчийн нэг удаагийн сургалтын зардлын дээд хэмжээ:

/төгрөгөөр/

| № | Зардлын нэр | Нэг удаагийн сургалтын зардлын дээд хэмжээ |
|------|----------------------|--|
| 1 | Бичиг хэргийн зардал | 5000 |
| 3 | Цайны зардал | 3000 |
| 4 | Унааны мөнгө | 1000 |
| 5 | Дадлагын материал | 2500 |
| Нийт | | 11500 |

Сургалтын нэр төрлөөс шалтгаалж дадлагын материал болон бусад зардал шаардагдахгүй тохиолдолд нийт зардлаас хасаж тооцно.

3. Өдөр тутмын харилцаанд орох дохионы хэлний анхан шатны сургалт

3.1. Дохионы хэлний анхан шатны сургалт нь 16 цаг, 32 цагийн гэсэн 2 төрөлтэй байна.

3.2. Дохионы хэлний анхан шатны 16 цагийн сургалтад бичиг үсэг тайлагдсан сонсголын бэрхшээлтэй иргэн, 32 цагийн сургалтад бичиг үсэг тайлагдаагүй сонсголын бэрхшээлтэй иргэн хамрагдана.

3.3. Дохионы хэлний анхан шатны 16 цагийн сургалтын зардал 155000, 32 цагийн сургалтын зардал нь 310000 төгрөг байна.

3.4. Дохионы хэлний анхан шатны сургалтад нэг багшид ноогдох анги дүүргэлт өөр өөр байх бөгөөд 1-ээс дээш 10 хүртэл суралцагч суралцана.

3.5. Дохионы хэлний сургагч багшийн ажлын нэг цагийн хөлсийг 20000 төгрөгөөр тооцно.

3.6. Суралцагчид унааны мөнгө өдрийн 1000 төгрөгөөр тооцож олгоно.

3.7. Сургалтад хамрагдаж буй сонсголын бэрхшээлтэй иргэнд 1 өдрийн 3000 төгрөгөөр тооцож цайны зардал олгоно.

4. Цагаан таяг эзэмшиж сурах болон хөдөлгөөн, орон зайн чиг баримжаа олгох сургалт /Харааны бэрхшээлтэй хүнд хөдөлгөөн орон зайн чиг баримжаатай болох улмаар бүхий л орчинд бие даан цагаан таяг болон бусад туслах хэрэгслийн тусламжтайгаар аюулгүй зорчиход нь шаардлагатай мэдлэг чадвар, дадлыг эзэмшүүлэх сургалт /

4.1. Цагаан таяг эзэмшиж сурах болон хөдөлгөөн, орон зайн чиг баримжаа олгох сургалт нь үндсэн сургалт, ажил, орон байрны шинэ орчинд дасгах нэмэлт сургалт гэсэн хоёр төрөлтэй байна.

4.2. Үндсэн сургалт 30 хоног, нэмэлт сургалт 15 хоног үргэлжлэнэ.

4.3. Цагаан таяг эзэмшиж сурах болон хөдөлгөөн, орон зайн чиг баримжаа олгох сургалт өдөрт 4 цаг үргэлжлэнэ.

- 4.4. Сургалтын хэрэгсэл, гарын авлагыг сургалт зохион байгуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хариуцна.
- 4.5. Сургалтад хамрагдаж буй харааны бэрхшээлтэй иргэнд 1 өдрийн 3000 төгрөгөөр тооцож цайны зардал олгоно.
- 4.6. Сургагч багшид унааны мөнгө өдрийн 1000 төгрөгөөр тооцож олгоно.
- 4.7. Цагаан таяг эзэмшиж сурах болон хөдөлгөөн, орон зайн чиг баримжаа олгох сургалтын 1 цагийн зардал 20000 төгрөг байх бөгөөд 16500 төгрөгийг сургагч багшид, 3500 төгрөгийг сургалт явуулж буй төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зардалд зарцуулна.

5. Брайль бичгийн сургалт

- 5.1. Брайль бичгийн сургалт нь 40 цаг , 60 цагийн гэсэн 2 төрөлтэй байна.
- 5.2. Хожуу хараагүй болсон бичиг үсэг тайлагдсан харааны бэрхшээлтэй иргэн 40 цаг, бичиг үсэг мэдэхгүй харааны бэрхшээлтэй иргэн 60 цагийн сургалтад хамрагдана.
- 5.3. Брайль бичгийн сургалтын 1 удаагийн анги дүүргэлт 5 хүн байна.
- 5.4. Брайль бичгийн сургалт өдөрт 4 цаг үргэлжлэнэ.
- 5.5. Брайль бичгийн сургалтад хамрагдах харааны бэрхшээлтэй хүний сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын ном сурах бичиг , гарын авлагыг сургалт зохион байгуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хариуцна.
- 5.6. Сургалтад хамрагдаж буй харааны бэрхшээлтэй иргэнд 1 өдрийн 3000 төгрөгөөр тооцож цайны зардал олгоно.
- 5.7. Брайль бичгийн сургалтын 1 цагийн зардал 20000 төгрөг байх бөгөөд 16500 төгрөгийг сургагч багшид, 3500 төгрөгийг сургалт явуулж буй төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зардалд зарцуулна.

6. Туслах технологийн сургалт / Гар утас, дейзи тоглуулагч, дэлгэц уншигч программ хангамж бүхий компьютер, брайль компьютер болон бусад туслах хэрэгсэл технологийн сургалт /

- 6.1. Туслах технологийн сургалт нь 40 цаг, 60 цагийн гэсэн 2 төрөлтэй байна.
- 6.2. Компьютерийн анхан шатны мэдлэгтэй харааны бэрхшээлтэй иргэн 40 цаг, анхлан суралцагч харааны бэрхшээлтэй иргэн 60 цагийн сургалтад хамрагдана.
- 6.3. Туслах технологийн сургалтын 1 удаагийн анги дүүргэлт 3 хүн байна.
- 6.4. Туслах технологийн сургалт өдөрт дээд тал нь 4 цаг хүртэл үргэлжлэнэ.
- 6.5. Сургалтад хамрагдаж буй харааны бэрхшээлтэй иргэнд 1 өдрийн 3000 төгрөгөөр тооцож цайны зардал олгоно.
- 6.6. Туслах технологийг сургалтын 1 цагийн зардал 20000 төгрөг байх бөгөөд 16500 төгрөгийг сургагч багшид, 3500 төгрөгийг сургалт явуулж буй төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зардалд зарцуулна.

7. Ахуйн сургалт / Харааны бэрхшээлтэй хүнд бие даан өдөр тутмын амьдралаа ахуйн хүрээнд аюулгүй зөв зохион байгуулах чадварыг эзэмшүүлэх сургалт /

- 7.1. Ахуйн сургалт нь 60 цаг байна. Сургалтын 1 удаагийн анги дүүргэлт 2 хүн байна.
- 7.2. Ахуйн сургалт өдөрт дээд тал нь 4 цаг хүртэл үргэлжлэнэ.
- 7.3. Ахуйн сургалтад хамрагдах 1 харааны бэрхшээлтэй иргэний сургалтын материал, хэрэгслийн зардал 120000 төгрөг байна.
- 7.4. Сургалтанд хамрагдаж буй харааны бэрхшээлтэй иргэнд 1 өдрийн 3000 төгрөгөөр тооцож цайны зардал олгоно.
- 7.5. Туслах технологийн сургалтын 1 цагийн зардал 20000 төгрөг байх бөгөөд 16500 төгрөгийг сургагч багшид, 3500 төгрөгийг сургалт явуулж буй төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зардалд зарцуулна.

7.6. Ахуйн сургалтад хамрагдах иргэний сургалтын материал, хэрэгслийн зардлыг сургалт зохион байгуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хариуцна.

8. Өдөр тутмын үйлдэл хийхэд шаардлагатай ахуйн болон тэргэнцэр, туслах хэрэгсэл зэргийг ашиглах сургалт

8.1. Үндсэн сургалт 7 хоног, сургалтад хамрагдаж буй хүний хөгжлийн бэрхшээлийн хүндрэлээс хамааран нэмэлт сургалт 7 хоног үргэлжилж болно.

8.2. Ахуйн болон тэргэнцэр, туслах хэрэгсэл зэргийг ашиглаж сурах сургалт нь хүмүүсийн хэрэгцээнээс хамааран сард 1 удаа зохион байгуулагдана. Нэг удаагийн сургалтад 1-ээс 15 хүртэл суралцагч хамрагдана.

8.3. Ахуйн болон тэргэнцэр, туслах хэрэгсэл зэргийг ашиглаж сурах сургалт өдөрт дээд тал нь 4 цаг хүртэл үргэлжлэнэ.

8.4. Сургагч багшийн ажлын нэг цагийн хөлсийг 20000 төгрөгөөр тооцно.

8.5. Сургагч багшид унааны мөнгө өдрийн 1000 төгрөгөөр тооцож олгоно.

8.6. Сургалтанд хамрагдаж буй тэргэнцэртэй иргэнд 1 өдрийн 3000 төгрөгөөр тооцож цайны зардал олгоно.

9. Зөвлөлдөх бүлэг буюу зөвлөгөө өгөх үйлчилгээ

9.1. Зөвлөлдөх бүлэг буюу зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх иргэн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүээр сарын 25-ны өдрийн А/187 дугаар тушаалаар баталсан “Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд тавигдах шалгуур”-ыг баримтлана.

9.2. Зөвлөлдөх бүлэг буюу зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх иргэн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн байна.

9.3. Зөвлөлдөх бүлэг буюу зөвлөгөө өгөх үйлчилгээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт заасан 18 ба түүнээс дээш насны иргэн хамрагдана.

9.4. Зөвлөгөө өгөх үйлчилгээний өрөөнд хэт хувийн чанартай зүйлс (гэр бүлийн зураг гэх мэт) үйлчлүүлэгчийн итгэл үнэмшилтэй холбоотой зүйлс (бурхан, загалмай гэх мэт) байлгах шаардлагагүй бөгөөд үйлчлүүлэгчийг тогтмол нэг өрөөнд хүлээж авна. Зөвлөгөө тодорхой хугацаатай үргэлжилнэ. Үйлчлүүлэгчтэй уулзах эхний болон дараа дараагийн уулзалт адил хугацаатай байна. Зөвлөгөөний эхэнд уулзах давтамжаа тогтооно.

9.5. Нэг удаагийн зөвлөгөө өгөх үйлчилгээ 40 минутаас доошгүй хугацаанд үргэлжилнэ.

9.6. Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах үйлчилгээ үзүүлэхэд хөгжлийн бэрхшээлийг өөрийн амьдралаараа туулан ялж, тодорхой туршлага, итгэл үнэмшил олсон хөгжлийн бэрхшээлтэй хүн энэхүү үйлчилгээг удирдан явуулна.

Харилцан зөвлөлдөгч нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүний тулгамдсан асуудлыг тодорхойлж чиглүүлэх ярилцлагын явцад тухайн хүний итгэл үнэмшлийг шинэчлэн тогтоох сэдлийг төрүүлэх, өөрийн эрхлэх болон явуулах үйл ажиллагаандаа орох ажлыг эхлүүлнэ.

9.7. Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах үйлчилгээ нь ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулагдана. Бүлгийн хэлбэрээр явуулахад харилцан бие биенээсээ суралцана.

9.8. Үйлчилгээ үзүүлсэн үр дүнгийн тэмдэглэл хөтлөнө.

9.9. Зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлэхэд олгох санхүүжилтийг тооцохдоо доорх үнийн тарифыг баримтлан зөвхөн гэрээнд зааж тухайн өдөр үзүүлсэн үйлчилгээний зардлыг санхүүжүүлнэ.

9.10. Зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ, шаардлагаас хамаарч 1-3 удаа хамрагдана.

9.11. Тухайн хүний сэтгэл зүйн байдлаас хамааран жилд 3 удаа үйлчилгээнд хамрагдаж болно.

/төгрөгөөр/

| № | Зардлын нэр | 1 удаагийн төлбөр |
|---|---|-------------------|
| 1 | Нийгмийн үйлчилгээний төрлөөр зөвлөгөө өгөх үйлчилгээ | 10000 |
| 2 | Эдийн засаг, санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ | 10000 |
| 3 | Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ | 10000 |
| 4 | Хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ | 10000 |
| 5 | Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээ | 10000 |

10. Хувийн туслах үйлчилгээ

- 10.1. Хувийн туслах үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/187 дугаар тушаалаар баталсан "Хувийн туслах үйлчилгээнд тавигдах шалгуур"-ыг баримтлана.
- 10.2. Хувийн туслах үйлчилгээний хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажилдаа ирж, очих, хувиараа хөдөлмөр эрхлэдэг бол бараа материалаа худалдан авах, сонгох, хэлэлцээр захиалга хийх, ажлын ярилцлаганд орох, ажилд зуучлах үйлчилгээнээс бусад зардлыг Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардлаас гаргана.
- 10.3. Хувийн туслах үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.6-д заасан иргэн хамрагдана.
- 10.4. Хувийн туслах үйлчилгээнд зорилтот бүлгийн иргэн өдөрт дээд тал нь 6 цаг хамрагдана. Үнэлгээгээр тогтоогдсон үйлчилгээний цагаа тухайн үйлчлүүлэгч үйлчилгээ үзүүлэх байгууллагатай тохиролцож сонгоно
- 10.5. Хувийн туслах үйлчилгээний 1 цагийн зардал нь 8500 төгрөг байх бөгөөд 4500 төгрөгийг хувийн туслах ажилтанд, 1500 төгрөгийг зардлыг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид, 2500 төгрөгийг нийгмийн даатгалд төлнө.
- 10.6. Хувийн туслах үйлчилгээний зардлын нэг цагийн үнийн дүнгийн 10 хувийг үйлчлүүлэгч хувь хүн өөрөө төлнө.
- 10.7. Гарын үсгээр баталгаажуулсан үйлчилгээ үзүүлсэн, үйлчилгээ авсан цагийн хүснэгттэй байна.
- 10.8. Хувийн туслах үйлчилгээг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхэд олгох санхүүжилтийг тооцохдоо гүйцэтгэлээр санхүүжилтийг олгоно.

11. Хувийн туслах ажилтан бэлтгэх сургалт

- 11.1. Хувийн туслах ажилтан бэлтгэх сургалт нь Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн баталсан хөтөлбөрийн дагуу явагдана. Хөтөлбөрт хүний эрхийн үндсэн ойлголт, эрхэм зэрэг, ХБХЭК-ийн үндсэн зарчим, үзэл санаа, хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээ, шаардлага, хувийн туслах нь хүний эрхийг хамгаалагч, хэрэгжүүлэгч мөн, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, ялгаатай хэрэгцээ, хөдөлмөрийн аюулгүй байдал гэсэн сэдвүүд хамран багтана. Найман цагийн онолын хичээл, 8 цагийн танхимын дадлага, 8 цагийн ажлын байран дахь дадлага багтана.
- 11.2. Хувийн туслах бэлтгэх сургалт 3-5 хоног үргэлжилнэ.
- 11.3. Хувийн туслах бэлтгэх сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний туслах хэрэгсэлийн бүрэн хангамжтай анги танхимд явагдана.
- 11.4. Хувийн туслах бэлтгэх сургалтад 1-ээс дээш 14 хүртэл суралцагч суралцана.

11.4. Хувийн туслах бэлтгэх сургалтын нэг хүнд ноогдох сургалтын зардал 40000 (дөчин мянган төгрөг) байна.

11.5. Хувийн туслах ажилтан болох сонирхолтой хүнийг эхний ээлжид ярилцлагад оруулан урьд өмнө гэмт хэрэгт холбогдож байгаагүй, зан суртхууны зөв хэвшилтэй хүнийг сонгон авна.

11.6. Хувийн туслах ажилтан нь цаг чанд баримталдаг, хариуцлагатай, харилцааны соёлтой, багаар ажиллах чадвартай хүн байна.

